



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

### НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн **Хүний нөөцийн хөгжлийн албаны даргын** ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

#### Гүйцэтгэх үүрэг:

- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээ болон ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах
- Эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах
- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварт үнэлгээ хийх, тэдгээрт мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах
- Эрүүл мэндийн удирдах ажилтныг хөгжүүлэх болон эрүүл мэндийн ажилтныг гадаад улс оронд суралцуулах, эрэлт хэрэгцээг судлах, нэгдсэн төлөвлөлт хийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, шалгалт авах, сорилын санг баяжуулах, үнэлэх, нууцлал, аюулгүй байдалд удирдлага, арга зүйгээр хангах

#### Тавигдах шаардлага:

- Анагаах ухаан, Нийгмийн эрүүл мэнд чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
- Төрийн албанд 5-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх
- Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах ур чадвартай байх
- Шударга, ёс зүйтэй, зарчимч байх
- Эерэг харилцаа, хандлагатай байх

#### Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет
- Их дээд сургууль төгссөн мэргэжлийн дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулах)
- Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 3x4 цээж зураг - 2%

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэдийн материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б)-ийн 1 дүгээр байр, 2 давхар, 203 тоот өрөөнд 2022 оны 11 сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд хүлээн авна.  
Утас: 70128805

**ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН АЛБА**

**2022.10.20**